



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/75

Алтанбулаг

Хөдөлгөөний хязгаарлалт тогтоох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 23 дугаар зүйлийн 23.1, 23.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, Сумын онцгой комиссын 2021 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэлэнгэ аймагт коронавируст халдвар /ковид-19/-ын батлагдсан тохиолдолд илэрч байгаатай холбогдуулан Сүхбаатар сум болон бусад аймаг, сум, хот руу зорчих нэн шаардлагатай /ар гэрийн гачигдал, эм эмнэлгийн үйлчилгээ, өвс тэжээл, хүнс тээвэр/ иргэд нэвтрэх зөвшөөрлийн бичгээр зорчихыг зөвшөөрсүгэй
2. Нэвтрэх зөвшөөрлийн бичгээр сумаас орох, гарах иргэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг өглөөний 06:00 цагаас 22:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
3. Төв замын хяналтын цэгийн хяналтыг сайжруулж сумаас орох гарах иргэдийн бүртгэлийг нэгтгэж өдөр бүр мэдээ тайлан өгч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн, шуурхай штабын орлогч дарга /Д.Амартүвшин/-д даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, шуурхай штабын дарга /У.Янжиндулам/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ

